



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.3 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор
ТУШААХ НЬ:

Нэг. Эрүүл мэндийн байгууллагуудад халдваргүйжүүлэх бодисын жилийн хэрэгцээг тооцох аргачлалыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү аргачлалыг ашиглан тухайн жилд шаардагдах халдваргүйжүүлэх бодисын хэрэгцээ, зардлыг тооцоолон жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү хөрөнгө оруулалтын газар (Д.Отгонбаатар), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал, ерөнхий эмч нарт даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
6 сарын 7 өдрийн 19-тоот
тушаалын хавсралт

Эрүүл мэндийн байгууллагуудад халдваргүйжүүлэх бодисын
жилийн хэрэгцээг тооцох аргачлал

Нэг. Үндэслэл

Халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд халдваргүйжүүлэх арга хэмжээ чухал юм. Халдвар дамжих, тархах гол эх булаг нь өвчтэй хүн, амьтан байдаг бөгөөд тэдгээрийн бохирдуулж халдвартай болгосон гадаад орчны хүчин зүйл, эд зүйлсээр дамжин халдвар тархдаг байна.

Улсын хэмжээнд 2011 онд эмнэлгээс шалтгаалсан халдварын 85 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд, халдварт өртөлтийг эмнэлэгт хэвтсэн 100 эмчлүүлэгч тутамд авч үзэхэд аймгуудад 2.3%, нийслэлд 3%, улсад дунджаар 2.6% байна. Халдварт өртөлтийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл нярайн тусламж үйлчилгээний үед ахуйн хавьтлын замаар 45%, шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх үед 22%, эх амаржих үед 18%, мэс ажилбар хийх явцад 8%, хатгалттай холбоотой халдварт өртөх нь 7% байна. Зонхилон бүртгэгдэж байгаа халдварууд нь гарын эрүүл ахуйн сахилтын дэглэм алдагдах, давтан хэрэглэгддэг багажны халдваргүйтгэл, угаалга, ариутгал шаардлагын түвшинд хийгдээгүй, нэг удаагийн хэрэглээний багажийг давтан хэрэглэдэг, тарилгын аюулгүй байдал хангалтгүй зэрэг эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлаж ажиллаагүйтэй холбоотой байна. Эрүүл мэндийн байгууллагуудад халдваргүйжүүлэх үйл ажиллагаа чанар, үр дүнгүй байгаагаас эмнэлгээс шалтгаалах халдвар гарах нэг нөхцөл болж байна.

Сүүлийн үед эмгэг төрүүлэгчийн шинж чанар хувьсан өөрчлөгдөж, антибиотикийн үйлчлэлд тэсвэртэй шинжийг агуулсан нянгийн омгийн тоо өсөж, түүнд сонгомлоор үйлчлэх чадвартай халдваргүйжүүлэх уусмалууд түрэн гарч халдваргүйжүүлэлтийн технологид шинэчлэл гарч байна.

Иймд эрүүл мэндийн байгууллага бүр өвчин үүсгэгчийг гадаад орчинд эрс цөөрүүлэх, устгах замаар тэдгээрийн дамжих замыг таслан зогсооход

шаардлагатай халдваргүйжүүлэх бодисын хэрэгцээг урьдчилан зөв тооцож, түүний дагуу нөөцөө бүрдүүлэн байгууллагын жилийн төсөв, зардалдаа тусгах шаардлагатай байна.

Хоёр. Халдваргүйжүүлэх бодисын хэрэгцээг тооцох аргачлал

2.1. Халдваргүйжүүлэх бодисын жилийн хэрэгцээг тооцохдоо доорх томъёог ашиглана.

$$X = B_x + I_u + \Delta + \Theta_u$$

X – халдваргүйжүүлэх бодисын жилийн хэрэгцээ

B_x - байнгын халдваргүйтгэлд шаардлагатай бодисын жилийн хэрэгцээ (2.2-оос харах)

I_u -их цэвэрлэгээнд шаардлагатай бодисын жилийн хэрэгцээ (2.7-оос харах)

Δ-эмнэлгийн багаж хэрэгслийн халдваргүйтгэлд шаардлагатай бодисын жилийн хэрэгцээ (2.8-аас харах)

Θ_u-өдөр тутмын цэвэрлэгээ, халдваргүйтгэлд шаардлагатай бодисын жилийн хэрэгцээ (2.9-өөс харах)

2.2. Байнгын халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд шаардлагатай бодисын жилийн хэрэгцээг тооцохдоо доорх томъёог ашиглана.

$$B_x = \Gamma_x + T_x + \Gamma_t + B_x$$

Γ_x -гадаргууг халдваргүйжүүлэх бодисын хэмжээ (2.3-аас харах)

T_x -мебель эдлэл, сантехник бусад тоног төхөөрөмж, эд зүйлүүдийг халдваргүйжүүлэх бодисын хэмжээ (2.4-өөс харах)

Γ_t -гал тогооны хэрэгслийг халдваргүйжүүлэх бодисын хэмжээ (2.5-аас харах)

B_x -цус, цэр, шээс гэх мэт биологийн хаягдлыг халдваргүйжүүлэх бодисын хэмжээ (2.6-аас харах)

2.3. Гадаргуугийн халдваргүйжүүлэлтэд шаардагдах бодисын жилийн хэрэгцээг тооцохдоо доорх томъёог ашиглана.

$$Г_x = Н * К * Т_{ш} * 365$$

Н- 1 м.кв талбайд зарцуулагдах бодисын хэмжээ

К- өдөрт халдваргүйтгэл хийх тоо /хэмжээ/

Т_ш- шалны нийт талбайн хэмжээ

365- жилийн хоног

2.4. Тоног төхөөрөмж, эд зүйлсийг халдваргүйжүүлэх бодисын жилийн хэрэгцээг тооцохдоо доорх томъёог ашиглана.

$$Т_x = Н * К * Т_t * 365$$

Т_t - тоног төхөөрөмжүүдийн талбайн хэмжээ

2.5. Гал тогооны сав, хэрэгслүүдийг халдваргүйжүүлэхэд шаардагдах бодисын жилийн хэрэгцээг тооцохдоо доорх томъёог ашиглана.

$$Г_t = Н * К * С_{и} * 365$$

С_и - сав суулгын иж бүрдлийн тоо

2.6. Их цэвэрлэгээнд зарцуулагдах бодисын жилийн хэрэгцээг тооцохдоо доорх томъёог ашиглана.

$$И_x = Н * Г_t * 52$$

Г_t – халдваргүйжүүлэх гадаргуугийн талбай

52- жилд хийгдэх их цэвэрлэгээний тоо (7 хоногт 1 удаа)

2.7. Эмнэлгийн багаж хэрэгслийг халдваргүйжүүлэхэд шаардагдах бодисын жилийн хэрэгцээ

$$\text{Эб} = \text{Д}_3 + \text{Т}_3 + \text{М}_3 + \text{Ш}_6 + \dots$$

Д₃ - дахин хэрэглэгддэг зүү тариурыг халдваргүйжүүлэхэд шаардагдах бодисын жилийн хэрэгцээ

Т₃ - эх барих, эмэгтэйчүүдийн багаж хэрэгслийг халдваргүйжүүлэхэд шаардагдах бодисын жилийн хэрэгцээ

Т₃ - мэс заслын багаж хэрэгслийг халдваргүйжүүлэхэд шаардагдах бодисын жилийн хэрэгцээ

Ш₆ - шүдний багаж хэрэгслийг халдваргүйжүүлэхэд шаардагдах бодисын жилийн хэрэгцээ гэх мэт

2.8. Өдөр тутмын хэрэгцээнд шаардагдах халдваргүйжүүлэх бодисын жилийн хэрэгцээ

$$\Theta_{\text{ц}} = \text{Н} * \text{О}_\text{т}$$

О_т - ор хоногийн тоо

Халдваргүйжүүлэх бодисын жилийн хэрэгцээний захиалгыг гаргахдаа хүлээн авах, тусгаарлах, гал тогоо зэрэг бүх тасаг нэгж, туслах албадыг хамруулна.